



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ГАНБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.19 № ХЭГ/2178

танай _____-ны № _____-т

Асуулт, асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-03/6560 дугаартай асуулга, 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 33 дугаартай асуултын дагуу Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөлтэй холбогдуулан гадаад, дотоод эх үүсвэрээс авсан зээл, түүний зарцуулалт, 2026 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрийн бүтээн байгуулалтын явц, Тамсагийн сав газраас нефть дамжуулах хоолой барих ажлын гүйцэтгэлийн явц болон үйлдвэрийг түүхий нефтээр хангах боломжтой бусад эх үүсвэрийн талаарх танилцуулга, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ⁰⁵ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265007273

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 06 дугаар сарын 19-ны
өдрийн 11.01/2178 тоот албан бичгийн
хавсралт

ТАНИЛЦУУЛГА, МЭДЭЭЛЭЛ

Асуулт:

1. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн улсын төсөв, дотоодын банк, Эрдэнэс Монгол нэгдэл болон Энэтхэгийн Эксим банк, бусад гадаад зээлээр авсан нийт хөрөнгө, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл

Хариулт:

“Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл” нь газрын тосны бүтээгдэхүүний дотоодын нийт хэрэгцээний 55 хувийг хангах бөгөөд энэхүү томоохон бүтээн байгуулалтын ажлыг 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байна. Тус бүтээн байгуулалтын төслийн менежментийн зөвлөхөөр Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Engineers India Limited”, EPC-01, EPC-02, EPC-03, EPC-04 багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгчээр “Megha Engineering & Infrastructure Limited” компани тус тус ажиллаж байна. Төслийн нийт зээлийн ашиглалт 439.0 сая ам.доллар байна.

Зээлийн ашиглаагүй үлдэгдэл 1,253.1 сая ам.доллар байгаа бөгөөд үйлдвэрийн бүтээн байгуулалтад 2026 онд 1.5 их наяд төгрөгийн зээлийг ашиглахаар төлөвлөөд байна.

Төслийн зээлийн эргэн төлөлтийн хувьд EPC-01 гэрээний эргэн төлөлт 2023 оноос эхэлсэн бөгөөд EPC-02, EPC-03, EPC-04 гэрээнүүдийн эргэн төлөлт 2030 оноос эхэлнэ. 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар үндсэн төлбөрт 45.9 сая ам.доллар, хүүгийн төлбөрт 15.7 сая ам.доллар, хөрөнгө баталгаажуулсны төлбөрт 14.1 сая ам.долларын тус тус төлж, нийт зээлийн эргэн төлөлтөд 82.9 сая ам.долларын төлбөрийг төлөөд байна.

Монгол Улсын Хөгжлийн банк, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” /“МГТБҮ”/ ТӨХХК хооронд 2018 онд байгуулсан гэрээний дагуу 248.7 тэрбум төгрөгийн зээлийн шугам нээж, “МГТБҮ” ТӨХХК нь Үйлдвэрийн гаднах дэд бүтэц (автозам, төмөр зам, ЦДАШ, талбайн тэгшилгээ) Газрын тосны үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалт, уг компанийн үйл ажиллагааг санхүүжүүлж байсан. Зээлийн санхүүжилт 2022 оны 07 дугаар сараас зогссон. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 82 дугаар тогтоолоор “МГТБҮ” ТӨХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-д нэгтгэн зохион байгуулсан. Нийт зээлийн ашиглалт 186.3 тэрбум бөгөөд хуримтлагдсан хүүгийн хэмжээ 143.4 тэрбум төгрөг байна. Тус хуримтлагдсан хүүгийн төлбөр болон зээлийг үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагааны орлогоороо төлөх юм.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2018 оны 11 дүгээр сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулж, төслийн нийт өртгийг 1,236.0 сая ам.доллар байхаар тооцсон. Улмаар тус техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг 2023 оны 09 дүгээр сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулж, төслийн нийт өртгийг 1,698.2 сая ам.доллар болгон шинэчлэн тогтоосон бөгөөд шаардлагатай нэмэлт санхүүжилтийн

зээлийн гэрээг Улсын Их Хурал 2025 оны 01 дүгээр сард соёрхон баталж, одоогоор төлөвлөлт, инженерчлэлээс бүтээн байгуулалтын үе шатанд бүрэн шилжсэн бөгөөд 2028 онд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн санхүүжилтийн мэдээг Хүснэгт 1, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн эргэн төлөлтийн хуваарийг Хүснэгт 2-оос тус тус харна уу.

Хүснэгт 1. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн санхүүжилтийн мэдээ

							/ам.доллар/
№	Дэд зээлийн гэрээ	Ажлын нэр	Гүйцэтгэгч	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	EPC-01	НТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ	Engineers India Limited	2017.05.01	1,450,000.0	1,450,000.0	-
2		Зөвлөх үйлчилгээ	Engineers India Limited	2019.05.13	73,300,433.0	52,293,995.7	21,006,437.3
3		Технологийн бус барилга байгууламж	Kalpataru Power International Limited	2019.10.13	97,800,000.0	97,522,787.2	277,212.8
4		Хүхэр ялгах байгууламж /лиценз/	БНФУ-ын Axens	2022.04.01	1,998,000.0	810,425.0	1,187,575.0
5		Устөрөгч үйлдвэрлэх байгууламж /лиценз/	Итали улсын Kinetics Technology	2022.04.01	3,815,563.0	1,198,911.5	2,616,651.5
6		Шингэрүүлсэн шатдаг хийг ялгах байгууламж /лиценз/	АНУ-ын UOP	2022.04.20	1,810,000.0	805,000.0	1,005,000.0
7		Дизелийн гидроцэвэрлэгээний байгууламж /лиценз/	АНУ-ын UOP	2022.04.21	6,628,270.0	4,765,000.0	1,863,270.0
8		Бензин боловсруулах байгууламж /лиценз/	АНУ-ын UOP	2022.05.10	3,796,897.0	2,308,200.0	1,488,697.0
9		Гидрокрекинг байгууламж /лиценз/	АНУ-ын UOP	2022.05.22	8,178,270.0	6,382,500.0	1,795,770.0
10		Висбрекинг байгууламж /лиценз/	Голланд улсын Shell Global Solution International	2022.06.10	4,775,000.0	3,245,000.0	1,530,000.0
11	EPC-02	Анхдагч процессын болон дагалдах байгууламжууд	Megha Engineering & Infrastructure Limited	2022.10.28	598,900,000.0	145,795,976.3	453,104,023.7
12	ECP-03	Үйлдвэрийн цахилгаан станц	Megha Engineering &	2022.10.28	189,720,000.0	44,699,225.7	145,020,774.3

			Infrastructure Limited				
13	ECP-04	Лицензтэй технологийн байгууламжууд	Megha Engineering & Infrastructure Limited	2023.09.29	648,000,000.0	77,762,868.4	570,237,131.6
15		Магадлашгүй ажлын зардал	-	-	52,000,000.0	-	52,000,000.0
Нийт					1,692,172,433.0	439,039,889.8	1,253,132,543.2

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 2. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн эргэн төлөлтийн хуваарь

№	Он	ЕРС-01	ЕРС-02	ЕРС-03	ЕРС-04	НИЙТ
1	2023	13,112,415.6				13,112,415.6
2	2024	13,112,415.6				13,112,415.6
3	2025	13,112,415.6				13,112,415.6
4	2026	13,112,415.6				13,112,415.6
5	2027	13,112,415.6				13,112,415.6
6	2028	13,112,415.6				13,112,415.6
7	2029	13,112,415.6				13,112,415.6
8	2030	13,112,415.6	22,185,185.2	7,037,037.0	45,164,000.0	87,498,637.9
9	2031	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
10	2032	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
11	2033	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
12	2034	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
13	2035	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
14	2036	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
15	2037	13,112,415.6	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	116,720,860.1
16	2038	6,556,207.9	44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	110,164,652.4
17	2039		44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	103,608,444.5
18	2040		44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	103,608,444.5
19	2041		44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	103,608,444.5
20	2042		44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	103,608,444.5
21	2043		44,370,370.4	14,074,074.1	45,164,000.0	103,608,444.5
22	2044				45,164,000.0	45,164,000.0
23	2025				22,540,000.0	22,540,000.0
	НИЙТ	203,242,442.5	599,000,000.0	190,000,000.0	700,000,000.0	1,692,242,442.5

Эх сурвалж: Сангийн яам

Асуулт:

2.Газрын тос боловсруулах үйлдвэрийн нийт бүтээн байгуулалтын 2026 оны эхний хагас жилийн байдлаар хэдэн хувьтай үүнээс үйлдвэрлэлийн үндсэн технологийн ба дэд бүтцийн барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцын талаарх мэдээлэл

Хариулт:

Төслийн бүтээн байгуулалтын ажил 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ЕРС-02 буюу Анхдагч технологийн болон дагалдах байгууламжууд-59,4%, ЕРС-03 буюу Дулааны цахилгаан станц-44,0%, ЕРС-04 буюу Лицензит байгууламжууд-9,4%, төслийн гүйцэтгэл нийлбэр дүнгээр 40,0%-тай байна.

Хүснэгт 3. "EPC-02 багц буюу Анхдагч технологийн байгууламжийн ажлын гүйцэтгэл.

Ажлын төрөл	Нэгж	Батлагдсан зургийн дагуу хийгдэх ажил	Тайлант хугацааны гүйцэтгэл	Нийт гүйцэтгэл	Нийт гүйцэтгэл (хувь)
Ухмалын ажил	м ³	498,363	-	425,538	85.4
Бетон цутгалтын ажил	м ³	8,322	3	6,268	75.3
Арматурын ажил	тн	12,977	14	8,790	67.7
Төмөр бетон цутгалт	м ³	131,641	2,282	83,412	63.4
Дүүргэлтийн ажил	м ³	400,184	305	267,145	66.8
Ган бүтээцийн ажил	тн	20,844	96	6,227	29.9
Агуулах сав, резервуарын ажил					
Үйлдвэрлэл	тн	10,250	32	9,773	95.3
Угсралт	тн	10,250	21	7,640	74.5
Далд шугам хоолойн ажил					
Үйлдвэрлэл	инч Ø	61,000	1,646	36,626	60.0
Шугам хоолойн буулгалт	инч м	225,000	-	118,946	52.9
Ил шугам хоолойн ажил					
Үйлдвэрлэл	инч Ø	385,000	1,951	112,755	29.3
Угсралт	инч м	1,341,316	12,326	183,373	13.7
Галын усны шугам					
Үйлдвэрлэл	инч Ø	197,685	1,068	15,526	7.9
Угсралт	инч м	448,000	-	-	-

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам

Хүснэгт 4. "EPC-03 багц буюу Үйлдвэрийн Дулааны цахилгаан станцын ажлын гүйцэтгэл.

Ажлын төрөл	нэгж	Батлагдсан зургийн дагуу хийгдэх ажил	Тайлант хугацааны гүйцэтгэл	Нийт гүйцэтгэл	Нийт гүйцэтгэл (хувь)
Газар шорооны ажил	м ³	70,262	-	70,182	99.9
Бетоны ажил	м ³	1,289	-	1,200	93.1
Арматурын бэхэлгээ	тн	2,176	8	2,060	94.7
Төмөр бетон цемент	м ³	27,890	632	18,234	65.4
Буцааж дүүргэх	м ³	54,440	330	32,602	59.9
Далд шугам хоолойн ажил					
Үйлдвэрлэл	инч Ø	6,500	-	1,862	28.6
Үе тавих	инч м	17,650	-	4,775	27.1
Бойлерын гадна бүрхүүлийн үйлдвэрлэл	тн	2,789	-	2,193	78.6

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам

Хүснэгт 5. EPC-04 багц буюу Лицензтэй технологийн байгууламжийн ажлын гүйцэтгэл.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор багц ажлын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээ байгуулах эрхийг олгож, төсөл хэрэгжүүлэгч Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч компани хооронд барилга угсралтын гэрээг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан. Одоогийн байдлаар

зургийн дагуу цутгалт хийх 14693 м³ төмөр бетоноос 5663 м³ цутгалт хийгдсэн, хүхэр ялгах байгууламжийн газар шорооны ажил, дэд станцын төмөр бетон цутгалтын ажил эхэлсэн байна.

Бараа материал	Нэгж	Нийт	Захиалсан хэмжээ	Хүлээн авсан
Арматур төмөр	тн	20,277	20,277	16,388
Суурийн бэхэлгээний боолт	ш	16,761	16,761	10,885
Ган бүтээцийн хэсэгчлэн үйлдвэрлэлт	ш	10,414	12,491	6,267
Талбай дээр хийгдэж буй ган бүтээц	ш	24,047	23,927	7,998
Агуулах савны хавтангууд	тн	8,842	8,842	8,746
Давсгүйжүүлэх тоног төхөөрөмжийн ган хавтан, дагалдах бүтээцийн хамт	тн	241	241	209
Хийн түлшний хэвтээ савны ган хавтан	тн	2,122	2,122	1,800
Далд шугам хоолой	км	27	27	27
Ил шугам хоолой	км	262	262	166
Галын усны шугам хоолой	км	55	55	27
Агуулах савны шугам хоолой	км	16	16	16
Хөнгөн блок	м ³	17,600	17,600	2,422

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам

Асуулт:

Тамсагийн сав газраас нефть дамжуулах хоолой татах ажлын гүйцэтгэлийн явц болон үйлдвэрийг нефтээр тасралтгүй хангах бусад эх үүсвэрийн талаарх мэдээлэл

Хариулт:

Газрын тос боловсруулах үйлдвэрт тос дамжуулах 530 км урттай шугам хоолойн ажил 89,8%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд инженерчлэл 93,9%, худалдан авалт 96,7%, барилга угсралт 82,2% -ийн тус тус гүйцэтгэлтэй. Тухайлбал шугам хоолойг сувгийн дагуу байрлуулах ажил 526 км, Хоолойн гагнуурын ажил, үл эвдэх сорилын ажил, зэврэлтээс хамгаалах будгийн ажил, дулаалгын ажил тус тус 522 км, хоолойн ухмалын ажил, хоолойг буулгах ажил, хоолойг булах ажил тус тус 521 км, хоолойн усан шахалтын тест 456 км хийгдсэн дүнтэй байна.

Монгол Улсын хэмжээнд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 4 талбайд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байна. Өнөөгийн байдлаар Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд Петрочайна Дачин Тамсаг ХХК, 1997 оны БХГ-т талбайд Доншен Газрын тос (Монгол) ХХК, Матад ХХ талбайд Петроматад ХХК нь тус тус газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Мөн газрын тосны хайгуулын Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ашиглалтын баталгаат нөөцийг 1,1 сая баррель буюу 160,4 мянган тонн нөөцийг хүлээн авч шийдвэрлэсэн. Ингэснээр Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд газрын тосны нийт баталгаат геологийн нөөц 335,6 сая тонн, үүнээс олборлох боломжтой буюу ашиглалтын нөөц 31,57 сая тонн байна. Газрын тостой холбоотой үйл ажиллагааг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад тулгуурлан явуулах зорилгоор газрын тосны хайгуулын 16 талбайд шинээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад байна. Ингэснээр хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт нэмэгдэх, газрын тосны нөөц өсөх боломж нэмэгдэх юм.

---oOo---